КОВИД-19 өвчний үеийн ялгаварлан гадуурхалтын байдал ба сэтгэцийн зарим үзүүлэлт хоорондын хамаарлыг судалсан нь

Б.Баттуяа[1,2], З.Хишигсүрэн[1], Д.Оюунсүрэн[1]
[1]АШУҮИС, АУС, Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим
2Халдварт өвчин судлалын үндэсний төв
И-майл: battuya26@gmail.com
Утас: 90080845

Түлхүүр үг:

Гутаан доромжлох, түгшимтгий, гутрамтгай байдал, нийгмийн, өөрийн ялгаварлан гадуурхалт

Товч утга

Үндэслэл: Халдварт өвчинд нэрвэгдсэнээр ялгаварлан гадуурхалт болон гутаан доромжлолд өртөх нөхцлийг бүрдүүлдэг. Учир нь аливаа халдварт өвчин бол халдвартай хүмүүсийг нийгэм дэх үүргээ гүйцэтгэхэд нь хязгаарлалт үүсгэх, эсвэл халдварт нэрвэгдэгсдийг үхэлд хүргэснээр олон нийтийн амьдрах чадварт заналхийлэл учруулах болно (Smith RA, Hughes D; 2014). Бид КОВИД-19 өвчнөөр өвдсөн иргэдийн ялгаварлан гадуурхалтын байдал ба сэтгэцийн зарим үзүүлэлт хоорондын холбоо хамаарлыг тодорхойлох зорилго тавин энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

Арга, аргачлал: Судалгааг тойм судалгааны агшингийн загвараар онлайн асуумж судалгааны аргыг ашиглан зохион байгуулав.

Үр дүн: Судалгаанд нийт 18-85 насны 339 хүн асуумж судалгаанд хамрагдсанаас эмэгтэй (n=225; 66.37%), эрэгтэй (n=114; 33.63%) хүйсийн харьцаа 3:1 байлаа. Судалгаанд хамрагдсан нийт оролцогчийн дундаж нас 38.7±.13.3 байсан ба 19.9%-29.7% нь 21-50 насны бүлгийн оролцогчид байсан. Нийт оролцогчийн нас, боловсрол, гэр бүлийн байдал, өрхийн орлогын бууралт, бие махбодын суурь өвчин эмгэгтэй эсэх зэрэг хүн амзүйн үзүүлэлтүүд хүйсийн хувьд ач холбогдол бүхий ялгаагүй байлаа. Харин судалгаанд оролцогчийн темперамент, сэтгэл түгшимтгий, гутрамтгай байдал болон нийгмийн ба өөрийн ялгварлан гадуурхалтын түвшин зэрэг үзүүлэлтүүд хүйсийн хувьд ач холбогдол бүхий ($p\leq0.001$) ялгаатай байв. Өөрийгөө ялгаварлан гадуурхах байдал өндөр түвшинд илрэхэд сэтгэл түгшимтгий, гутрамтгай байдал зэрэг үзүүлэлтүүд эерэг сул хүчтэй нийгмийн ялгаварлан гадуурхалтын түвшин өндөр байх нь эерэг дунд зэргийн хүчтэй нөлөөтэй болох нь ($p<0.05$) тогтоогдсон болно.

Дүгнэлт: КОВИД-19 өвчнөөр өвчлөгсөд нийгмийн болон өөрийн ялгаварлан гадуурхалтанд 98% өртсөн бөгөөд сэтгэл түгшимтгий, гутрамтгай байдал болон нийгмийн ялгаварлан гадуурхалтын байдал нь өөрийн ялгаварлан гадуурхалтын байдлыг статистик ач холбогдол бүхий нэмэгдүүлдэг ($p<0.05$) байна.

Үндэслэл: Ялгаварлан гадуурхалт нь гутаан доромжлогдох байдал буюу стигма /Stigma/-тай хамт явагддаг үзэгдэл бөгөөд хэн нэгнийг гутаан доромжлох нь нийгэмд тодорхой хүмүүст хандсан, гутаан доромжлох хандлага, зан үйл юм[1].

Халдварт өвчинд нэрвэгдсэнээр ялгаварлан гадуурхалт болон гутаан доромжлолд өртөх нөхцлийг бүрдүүлдэг. Учир нь аливаа халдварт өвчин бол халдвартай хүмүүсийг нийгэм дэх үүргээ гүйцэтгэхэд нь хязгаарлалт үүсгэх, эсвэл халдварт нэрвэгдэгсдийг үхэлд хүргэснээр олон нийтийн амьдрах чадварт заналхийлэл учруулах болно[2].

Ялгаварлан гадуурхалт гутаан доромжлол нь халдвар эсвэл хорио цээрийн дэглэмтэй холбоотой айдас, ташаа мэдээлэл, инфодемик буюу мэдээллийн тахал (жишээ нь ташаа мэдээлэл

хэт их тархах), өвчин туссанд өөрийгөө болон бусдыг буруутгах зэрэг нийгэм-экологийн олон хүчин зүйлийн үр дагавар байж болзошгүйг зарим судлаач цохон тэмдэглэжээ[3].

КОВИД-19 цар тахал нь сэтгэлийг гэмтээгч үйл явдал бөгөөд ялангуяа амьд үлдсэн хүмүүсийн хувьд сэтгэцийн эрүүл мэнд, амьдралын чанар, сайн сайхан байдалд ноцтой бөгөөд урт хугацааны сөрөг үр дагаврыг үүсгэж болзошгүй байна[4].

Иймд бид КОВИД-19 өвчнөөр өвдсөн иргэдийн ялгаварлан гадуурхалтын байдал ба сэтгэцийн зарим үзүүлэлт хоорондын холбоо хамаарлыг тодорхойлохыг зорьлоо.

Зорилго: КОВИД-19 өвчнөөр өвдсөн иргэдийн ялгаварлан гадуурхалтын байдал ба сэтгэцийн зарим үзүүлэлт хоорондын холбоо хамаарлыг тодорхойлох

Арга, аргачлал: Судалгааг тойм судалгааны агшингийн загвараар асуумж судалгааны аргыг ашиглан зохион байгуулав. Судалгааны ёсзүйн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэсэн. Оролцогчдын сэтгэцийн зарим үзүүлэлтийг (сэтгэл түгшилт, сэтгэл гутрал, хувь хүний сэтгэцийн хэв шинж буюу темперамент, ялгаварлан гадуурхалт) үнэлэхдээ олон улсын стандарт аргачлалыг ашиглалаа. Ялгаварлан гадуурхалтын байдлыг үнэлэх сорилд хариулсан оролцогчдын хариултын итгэгдэх байдлыг Кронбахын коэффициентоор тооцон үзэхэд нийгмийн ялгаврлан гадуурхалтыг үнэлэх болон (Cronbach alpha=0.88) өөрийн ялгаварлан гадуурхалтын үнэлэх асуумжинд хариулсан байдлын итгэгдэх чанар нь (Cronbach alpha=0.89) хангалттай түвшинд байв.

Үр дүн: Судалгаанд нийт 18-85 насны 339 хүн асуумж судалгаанд хамрагдсанаас эмэгтэй (n=225; 66.37%), эрэгтэй (n=114; 33.63%) хүйсийн харьцаа 3:1 байлаа. Судалгаанд хамрагдсан нийт оролцогчийн дундаж нас 38.7±.13.3 байсан ба 19.9%-29.7% нь 21-50 насны бүлгийн оролцогчид байсан. Нийт оролцогчийн хүн амзүйн зарим үзүүлэлтийг хүйсийн байдлаар харьцуулсан үр дүнг Хүснэгт 1-т нэгтгэн харуулав.

Хүснэгт 1. Хүн ам зүйн зарим хүчин зүйлсийн хамаарал

Хүчин зүйлс	Хүйс						P утга
	Эр n=114 (33.6%)		Эм n=225 (66.4%)		Бүгд (n=339)		
Насны бүлэг	N	(%)	N	(%)	N	(%)	
24 доош	20	17.5	22	9.8	42	12.4	
25-34	33	28.9	78	34.7	111	32.7	
35-44	26	22.8	61	27.1	87	25.6	0.225
45-54	15	13.1	36	16	51	15	
55-64	14	12.2	21	9.3	35	10.3	
65 ба түүнээс дээш	6	4.6	7	2.3	13	3.8	
Боловсролын байдал	N	(%)	N	(%)	N	(%)	
Дээд	73		170		243		0.07
Бүрэн дунд	25		40		65		
Бүрэн бус дунд	8		6		14		
Тусгай дунд	8		9		17		
Гэр бүлийн байдал	N	(%)	N	(%)	N	(%)	
Гэр бүлтэй	88	77.2	161	71.6	249	73.5	0.08
Ганц бие	20	17.5	36	16	56	16.5	
Салсан	5	4.4	22	8.1	23	10.2	
Бэлэвсэн							
Хамтран амьдрагчтай	1	0.9	5	2.2	6	1.8	
Өрхийн орлого буурсан эсэх	N	(%)	N	(%)	N	(%)	
Тийм	113	72.4	193	71	306	71.5	0.744
Үгүй	43	37.6	79	29	122	28.5	
Бие махбодын суурь өвчин эмгэг	N	(%)	N	(%)	N	(%)	0.07
Суурь өвчтэй	49	43	120	53.3	169	49.9	
Суурь өвчингүй	65	57	105	56.7	170	50.1	

Хүснэгт 1-ээс харахад, нийт оролцогчийн нас, боловсрол, гэр бүлийн байдал, өрхийн орлогын бууралт, бие махбодын суурь өвчин эмгэгтэй эсэх зэрэг хүн амзүйн үзүүлэлтүүд хүйсийн хувьд ач холбогдол бүхий ялгаагүй байсан.

Бид КОВИД-19 өвчний улмаас хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгсдийн сэтгэцийн эрүүл мэндийн зарим үзүүлэлтийг тодорхойлон хүйсээр харьцуулан нэгтгэхэд дараах үр дүн тогтоогдлоо (Хүснэгт 2).

Хүснэгт 2-д үзүүлснээр, тус судалгаанд хамрагдсан оролцогчдын 22.1% (n=75) нь сангвиник, 21.5% (n=73) нь флегматик, 39.8% (n=135) нь холерик, 16.6% (n=51) нь меланхолик хэв шинжийн темпераменттай байсан нь хүйсийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаатай (p≤0.001) үзүүлэлт байв.

Судалгаанд хамрагдсан нийт оролцогчийн 39.2% (n=133) нь сэтгэл түгшилгүй, 37.2% (n=126) нь бага зэргийн, 15.6% (n=53) нь дунд зэргийн сэтгэл түгшилттэй байсан бол 7.9% (n=27) нь хүнд зэргийн сэтгэл түгшилттэй байлаа.

Харин нийт оролцогчийн 30% (n=101) нь сэтгэл гутралгүй, 37.5% (n=127)-д сэтгэл гутралын түвшин бага, 20% (n=67)-д сэтгэл гутралын түвшин дунд зэрэг, 9% (n=31)-д хүндэвтэр, 4% (n=13)-д нь хүнд зэргийн сэтгэл гутралын түвшинтэй тодорхойлогджээ.

Хүснэгт 2. КОВИД-19 өвчний улмаас эмчлүүлж буй эмчлүүлэгсдийн сэтгэцийн эрүүл мэндийн зарим үзүүлэлт (хүйсээр)

Хүчин зүйлс	Хүйс						Р утга
	Эр n=114 (33.6%)		Эм n=225 (66.4%)		Бүгд (n=339)		
Темперамент	N	(%)	N	(%)	N	(%)	
Холерик	49	43	86	38.2	135	39.8	
Сангвиник	28	24.6	47	20.9	75	22.1	
Флегматик	21	18.4	52	23.1	73	21.5	0.001
Меланхолик	16	14	40	17.8	51	16.6	
Сэтгэл түгшилтийн түвшин	N	(%)	N	(%)	N	(%)	
Түгшилтгүй	65	57	68	30.2	133	39.2	0.001
Бага	34	29.8	92	40.9	126	37.2	
Дунд	12	10.5	41	18.2	53	15.6	
Хүнд	3	2.6	24	10.6	27	7.9	
Сэтгэл гутралын түвшин	N	(%)	N	(%)	N	(%)	
Гутралгүй	52	45.7	49	22.7	101	29.8	0.001
Бага	38	33.3	89	39.6	127	37.5	
Дунд	16 7	14 6.1	51 24	22.6 10.7	67 31	19.8 9.1	
Хүндэвтэр							
Хүнд	1	0.9	12	5.3	13	3.8	
Өөрийгөө дорд үзэх байдал	N	(%)	N	(%)	N	(%)	
Бага	15	13.1	7	3.1	22	6.5	0.001
Дунд	85	74.6	154	68.4	239	70.5	
Өндөр	14	12.3	64	28.4	78	23	
Нийгмийн гутаан доромжлол	N	(%)	N	(%)	N	(%)	0.003
Бага	4	3.5	0	0	4	1.2	
Дунд	42	36.8	62	27.6	239	30.7	
Өндөр	68	59.6	163	72.4	78	68.1	

Сэтгэл түгшилт болон сэтгэл гутралын байдлыг хүйсээр харьцуулан харахад эмэгтэй хүйсийн оролцогчийн дунд дээрх хоёр үзүүлэлт статистик ач холбогдол бүхий ялгаатай (p≤0.001) өндөр байв.

Нийт судалгаанд хамрагдсан оролцогчийн 98% нь ялгаварлан гадуурхалд өртсөн байсан ба тэдгээр оролцогчийн 36%-д нь өөрийн

гадуурхалтын түвшин дунд зэрэг, 61.9% нь өөрийн гадуурхалтын түвшин өндөртэй байсан. Оролцогчдын нийгмийн (p=0.003) болон өөрийн (p=0.001) ялгаварлан гадуурхалтын түвшин нь хүйсийн хувьд ач холбогдол бүхий ялгаатай байв.

Судалгаанд оролцсон эмчлүүлэгсдийн өөрийгөө ялгаварлан гадуурхах байдалд нөлөөлөх хүчин зүйлсийн харилцан хамаарлыг тодруулан шинжлэхэд, өөрийгөө ялгаварлан гадуурхах байдал өндөр түвшинд илрэхэд сэтгэл түгшимтгий (r=0.428*) ба гутрамтгай байдал (r=0.244*) зэрэг үзүүлэлтүүд сул хүчтэй эерэг нөлөөтэй байсан бол нийгмийн ялгаварлан гадуурхалтын түвшин өндөр байх (r=0.632*) нь эерэг дунд зэргийн хүчтэй нөлөөтэй болох нь (p<0.05) тогтоогдлоо.

Хэлцэмж: Халдварт өвчний үеийн ялгаварлан гадуурхалт нь дэлхийн нийтийн асуудал болоод байгааг олон судалгааны үр дүн нотлосон байдаг. Сүүлийн 10-аад жилийн хугацаанд олон судалгаануудад халдварт өвчний үеийн ялгаварлан гадуурхах байдлыг судласан нь зөвхөн ДОХ, сүрьеэ, SARS зэрэг өвчнөөр хязгаарлагдахгүй байна.5,6,7 КОВИД-19 цар тахлын эхний үеийн зарим судалгааны дүнгээр, амьд үлдсэн хүмүүсийн нийгмийн түгшүүрийн шалтгаан болох хоёрдогч хүчин зүйлд ялгаварлан гадуурхалт, халдвартай хүмүүстэй хамаарал бүхий хүмүүсийг гутаан доромжлох, нийгмийн дэмжлэг дутмаг гэх мэт нийгмийн болон хүн хоорондын харилцааны хүчин зүйлүүд оржээ. Коронавируст халдварын улмаас олон нийт сандралд автаж, амьд үлдсэн хүмүүсийг хэл амаар доромжлох, хов жив ярих, тэдний нийгмийн үнэ цэнийг бууруулах гэх мэтээр нийгмийн сөрөг хандлагыг үүсгэснээр амьд үлдэгсэд бусдын сөрөг хандлагыг мэдэрч ялгаварлан гадуурхагдан орон байрнаасаа татгалзахад хүрч байгааг зарим судлаач онцлон дурьдсан байна.8 Хамгийн эмзэг нөхцөл бол КОВИД-19 өвчтэй хүмүүс нь шинээр гарч буй цуу ярианд өртөмтгий, янз бүрийн хэлбэрийн гадуурхалд өртсөнөөр нийгмийн зай барилт, нийгмээс тусгаарлагдах, нийгэмд гадуурхагдах явдлыг улам бүр гүнзгийрүүлж байгаа юм. Нийгмийн гадуурхалтын энэхүү хэвийн бус үзэгдэл нь нийгмийн бүх харилцаанд сөргөөр нөлөөлж КОВИД-19 өвчинд нэрвэгдсэн хувь хүнийг “өөрийгөө ялгаварлан гадуурхан, дорд үздэг” нэгэн болгон хувиргаж нийгэм хамтын ажиллагаагүйгээр оршин тогтноход хүргэж байна хэмээн судлаачид цохон тэмдэглэжээ.[9,10]

Ялгаварлан гадуурхах, хавчин гадуурхах, үзэн ядах гэсэн нийгмийн гадуурхалт нь нийгэмд хүчтэй тархаж байна, яагаад гэвэл вирусыг хэн тээж яваа, хэн нь биш гэдгийг тодорхойлоход хэцүү байдаг. КОВИД-19 өвчний тохиолдол болон халдвар авсан бусад хүмүүсийг ойр дотны хүмүүсийнх нь хамт буруутгаж байна.[11,12]

Бидний судалгааны дүнгээс харахад, өөрийгөө ялгаварлан гадуурхах байдал өндөр түвшинд илрэхэд сэтгэл түгшимтгий, гутрамтгай байдал зэрэг үзүүлэлтүүд эерэг сул хүчтэй нийгмийн ялгаварлан гадуурхалтын түвшин өндөр байх нь эерэг дунд зэргийн хүчтэй нөлөөтэй болох нь (p<0.05) байгаа тул цаашид хүн амын дунд халдварт өвчний үеийн сэтгэл зүйн тусламж үйлчилгээ нэн шаардлагатай байгааг харуулж байна.

Дүгнэлт: КОВИД-19 өвчнөөр өвчлөгсөд нийгмийн болон өөрийн ялгаварлан гадуурхалтанд 98% өртсөн бөгөөд сэтгэл түгшимтгий, гутрамтгай байдал болон нийгмийн ялгаварлан гадуурхалтын байдал нь өөрийн ялгаварлан гадуурхалтын байдлыг статистик ач холбогдол бүхий нэмэгдүүлдэг (p<0.05) байна.

Ном зүй

1. *Smith R. Language of the lost: an explication of stigma communication. Commun Theory. 2007;17(4):462–485. doi: 10.1111/j.1468-2885.2007.00307*
2. *Smith RA, Hughes D. Infectious Disease Stigmas: Maladaptive in Modern Society. Commun Stud. 2014;65(2):132-138. doi:10.1080/10510974.2013.851096*
3. *Logie CH. Lessons learned from HIV can inform our approach to COVID-19 stigma. J Int AIDS Soc. 2020;23(5):e25504. doi:10.1002/jia2.25504*
4. *Ju N, Yang X, Ma X, et al. Hospitalization, interpersonal and personal factors of social anxiety among COVID-19 survivors at the six-month follow-up after hospital treatment: the minority stress model. Eur J Psychotraumatol. 2022;13(1):2019980. Published 2022 Jan 28. doi:10.1080/20008198.2021.2019980*
5. *Brooks SK, Webster RK, Smith LE, et al. The psychological impact of quarantine and how to reduce it: a rapid review of the evidence. Lancet. 2020;395(10227):912-920. doi:10.1016/S0140-6736(20)30460-8*
6. *Maunder, R., Hunter, J., Vincent, L., Bennett, J., Peladeau, N., Leszcz, M., & Mazzulli, T. The immediate psychological and occupational impact of the 2003 SARS outbreak in a teaching hospital. Canadian Medical Association Journal. 2003;168(10):1245–1251*

7. *Do Duy, C., Nong, V.M., Ngo Van, A., Doan Thu, T., Do Thu, N. and Nguyen Quang, T. COVID-19-related stigma and its association with the mental health of health-care workers after quarantine in Vietnam. Psychiatry Clin. Neurosci.,2020;74:566-568. doi:10.1111/pcn.13120*

8. *Ransing R, Ramalho R, de Filippis R, et al. Infectious disease outbreak related stigma and discrimination during the COVID-19 pandemic: Drivers, facilitators, manifestations, and outcomes across the world. Brain Behav Immun. 2020;89:555-558. doi:10.1016/j.bbi.2020.07.033*

9. *Hasan, M. T., Hossain, S., Saran, T.R., Ahmed, H. U. (2020). Addressing the COVID-19 related stigma and discrimination: A fight against infodemic in Bangladesh. File:///C:/users/HP/downloads/Preprint_COVID19 related stigma and discrimination_MTH.Pdf*

10. *Sotgiu, G., & Dobler, C. C. (2020). Social stigma in the time of coronavirus disease 2019. The European respiratory journal, 56(2), 2002461. https://doi.org/10.1183/13993003.02461-2020*

11. *Malecki K, Keating JA, Safdar N. Crisis Communication and Public Perception of COVID-19 Risk in the Era of Social Media [published online ahead of print, 2020 Jun 16]. Clin Infect Dis. 2020;ciaa758. doi:10.1093/cid/ciaa758*

12. *Shigemura J, Ursano RJ, Morganstein JC, Kurosawa M, Benedek DM. Public responses to the novel 2019 coronavirus (2019-nCoV) in Japan: Mental health consequences and target populations. Psychiatry Clin Neurosci. 2020;74(4):281-282. doi:10.1111/pcn.12988*

The relationship between stigma and some psychiatric variables of patients with COVID-19

Battuya B[1,2], Khishigsuren Z[1], Oyunsuren D[1]

[1]Department of Mental Health, SoM, MNUMS

[2]National Center of Communicable Diseases

Email: battuya26@gmail.com

Tel: 90080845

ABSTRACT

Introduction: Being affected by an infectious disease creates conditions for discrimination and stigmatization. Because any infectious disease threatens the viability of the community by limiting the ability of infected people to perform their roles in society or by causing the death of those infected (Smith RA, Hughes D; 2014).

Objective: We aimed to detect the relationship between stigma and some psychiatric variables of patients with COVID-19 disease.

Material and methods: The study was conducted using a descriptive cross-actional design, used a semi-structured questionnaire.

Results: Totally 339 patients aged 18-85 participated in the survey, and the gender ratio (women n=225, 66.37%; men n=114, 33.63%) was 3:1. The average age of total participants was 38.7±13.3, and 19.9%-29.7% of the participants were in the 21-50 age group. Demographic variables such as age, education, marital status, reduction of household income, and presence of underlying somatic problems of all participants did not have significant gender differences. Some psychiatric variables such as temperament, anxiety, depression, and social/self-stigma of all participants were significantly gender differences ($p \leq 0.001$). When self-stigma is detected at a high level, variables such as anxiety and depression are weakly positive, and the high level of social stigma had a positive moderate strong effect ($p<0.05$).

Conclusion: 98% of patients with COVID-19 were affected by social and self-stigma, and anxiety, depression, and high level of social stigma significantly increased self-stigma ($p<0.05$).

Keywords: Discrimination, anxiety, depression, social, self-stigma